



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/Н 27

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4. "а", 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төгрөг сумын хүн эмнэлгийн барилгын урсгал засварын зардалд 30,000,000 (гучин сая), "Онги-Ус суваг" ОНӨААТҮГазрын бохир усны төв шугамын угаалгын зардалд 15,700,000 (арван таван сая долоон зуун мянга) төгрөгийг тус тус зарцуулах эрхийг Төгрөг сумын Засаг дарга (Б.Батбаяр), "Онги-Ус суваг" ОНӨААТҮГазрын дарга (О.Лхагвасүрэн) нарт тус тус шилжүүлсүгэй.

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг Төгрөг сумын Засаг дарга, "Онги-Ус суваг" ОНӨААТҮГазрын дарга нарт даалгасугай.

3.Дээрх зардлыг аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100963

D:My Doc. Zahiramj. Zasag darga